

Хятадын цайны ёсонд цайг өнгө, үнэр, амт, хэлбэр хэмээсэн 4 талаас нь шинждэг ажээ.

Хятад хүн цайг машинд эрхэмлэхийн учир зочин гийчин ирэхүйд юуны өмнө цайгаар дайлах агаад энэ нь эрхэм дээд ёслол хүндэтгэл болдог. Үр ач нар нь өтгөс дээдэсдээ цай барьж хүндэтгэлээ илэрхийлэх ёс эртнээс уламжилж ирсэн байдаг. Доод хүн дээд хүндээ цай барих нь ихэд хүндэтгэсэний илрэл болно. Тан, Сүн улсын үеэс хятадад газар сайгүй цайны мухлаг (茶館) буй болж, эхэндээ наймаа арилжаа хэлэлцдэг гол газар байснаа аажмаар олны цугларах дуртай газар болжээ. Худалдаачид наймаа арилжаа хэлэлцэн, өтгөс хөгшид дэл сул үгс ярилцан, мягман даам, мажянь наадан, ахан дүүс харилцан биесээ хүндэтгэн, анд нөхөд чин сэтгэлийн үгсээ хэлэлцэн, чухамдаа түм түжигнэж, бум бужигнаж, олны хөлд дарагдан байх нь хятадын цайны мухлагийн дүр төрх, хятадын ард түмний уламжлалт соёлын өвөрмөц нэгэн онцлог билээ. Хятадын нэрт зохиолч Лао Шө (老舍) -гийн “Цайны мухлаг” (茶館) хэмээх алдарт жүжгийн зохиол байдаг.

Цайны соёлыг дагалдан цайтай холбоотой өдий төдүй өвөрмөц ёс заншил буй болжээ. Хурим найр болоход шинэ хүргэн, бэр нар хамгийн түрүүнд эцэг эхийн өмнө өвдөг сөгдөн, өсгөн бойжуулж, хүний зэрэгт хүргэсэн ач энэрлийг нь бишрэн хүндэлж, цайны дээж өргөн барьдаг, эцэг эх нь цайнаас амссаны дараа хурим найр эхэлдэг байна.

Цайны модыг заавал үрээр нь тарьж ургуулах бөгөөд соёлуулж шилжүүлэн суулгаж болдоггүй ажээ. Энэ нь ураг гэрийн бат бэхийн бэлгэдэл болох бөгөөд шинэ хосууд насан турш хоёр биендээ нэгэн сэтгэлээр үнэнч шударгуу явахын бэлгэдэл болгож цайны модны үр суулгадаг заншил буй. Түүнчлэн сүй тавьж, хуримын товыг тогтоож, хурим найр хийхдээ “гурван цайны бэлэг” (三茶礼) барьдаг ёс заншил эдүгээ хятадын өмнөд болон хойт нутагт хадгалагдсан хэвээр ажээ. Тиймийн учир

*Номгүйгээр гурав хонож болмуй*

*Цайгүйгээр ганц ч хонож үл болмой*

гэсэн мэргэн үг байдаг.

Хятадад цай аягалан барихад долоовор, дунд хоёр хуруугаа нийлүүлж хагас нумлан, ширээ зөөлөн тогшиж, цай барьсан хүнд талархсанаа илэрхийлдэг ёс буй. Энэ ёс хэдийвээр хятадын өмнө зүгийн Гуандун зэрэг нутагт голлон тархсан боловч эдүгээ хятадын олон газар нутагт түгээмэл дэлгэрсэн байна.

Тэнгэр тэтгэгч хаан (1736-1795) нэгэнтээ энгийн хувцас өмсөж, нутаг орноороо аялан явж гэнэ. Тэрбээр дагуул түшмэлдээ түүнийг хаан гэдгийг хэнд ч хэлэхгүй байхыг тушаажээ. Хаан нэгэн өдөр цайны мухлагт орж, өөртөө цай аягалаад, дараа нь бараа бологч түшмэлдээ бас цай аягалж өгч гэнэ. Хаан өөрт нь цай аягалах нь түшмэлийн хувьд асар том хүндэтгэл мөний тул зүй нь тэрбээр хааны өмнө өвдөг сөгдөн толгой бөхийн хүндэтгэх ёстой байв. Гэвч тийн үйлдвээс хаан хэн болох нь танигдах тул түшмэл арга сэдэн, долоовор дунд хоёр хуруугаараа ширээ зөөлөн тогшин, хаанд хүндэтгэлээ илэрхийлж гэнэ.

Өнөөг хүртэл уламжилж ирсэн ширээ тогшиж хүндэтгэл илэрхийлдэг заншил ийн үүссэн түүхтэй юм.

Цай хэмээх гайхамшигт идээ дэлхий дахинаа тархаж, алдарт “Цайны зам” үүссэн билээ.

Хятадын Юньнань Их сургууль, Бээжин Их сургуулийн хэсэг эрдэмтэд 1990 онд хэдэн сараар аялан явж, эртний цайны замыг сурвалжлан шинжилж, Юньнанаас эхтэй эртний цайны замын худалдаа хойд, зүүн, баруун, өмнө зүг салбарлан тархаж, уул даваа, ус мөрнийг гэтлэн, хятадын баруун бүс нутгийн олон муж газар нутгаар дайран, 30 гаруй үндэстний 80 сая гаруй хүнийг хамран, хойд зүгт “торгоны зам”-тай, өмнө зүгт “шаазангийн зам”-тай холбогдож, дэлхий дахинаа тархаж байсныг тогтоон нотолсон байдаг. Тийнхүү Хятад улс дэлхий дахинаа цай, шаазан, торго хэмээсэн гурван биет соёлыг түгээн дэлгэрүүлж, өмнө зүгийн “цайны зам”, хойд зүгийн “торгоны зам”, далайн “шаазангийн зам” бүрэлдэн буй болсон ажгуу.

Америкийн зохиолч эмэгтэй Марта Авери (Martha Avery) Монгол улсад нэлээд хэдэн жил ажиллаж амьдрахдаа цайны замын түүхийг сонирхон судалж, цайны зам Евроазийг хэрхэн хэлхэн холбосон түүхийг өгүүлсэн “Цайны зам” (“The tea road”) хэмээх сонирхолтой ном туурвиж, АНУ-д хэвлүүлснийг хятад хэлээр орчуулж Бээжинд хэвлэжээ. Энэ номд Монголын тухай, цайны зам Монголоор хэрхэн дайран өнгөрч байсан тухай сонирхолтой түүх өгүүлсэн байдаг. Түүнчлэн зохиогч номынхоо оршилд бичсэнээр Санктпетрбургийн түүхийн институтын архиваас олж цуглуулсан гэх XX зууны эхэн үеийн Монголын аж амьдралын дүр төрхийг хальснаа шингээн үлдээсэн олон ховор нандин гэрэл зургийг уг номд хавсаргасан байх бөлгөө.